




ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР

“ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА”
АЯН ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ

Авлигын эсрэг

...**НЭГДЭЭ**

Үгүй гэж хэлээд өөрчилье!  110

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР

“ШУДАРГА ЁС, ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА” АЯНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 08 дугаар сарын 16

Мандалговь хот

Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газраас санаачлан зохион байгуулж буй “Шударга ёс, хөгжил дэвшилд хамтдаа” аянд дараах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Нэг: Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар


Газрын бие бүрэлдэхүүн болон ХАСХОМ мэдүүлэг гаргагч албан хаагчид Авлига албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигаас ангид байх чиглэлээр мэдлэг, мэдээлэл олгох сургалт, мэдээлэлийг 2 удаа давхардсан тоогоор 21 алба хаагчийг хамруулсан.

Албан хаагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тэднийг гэмт хэрэг, ёс зүйн болон авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дотоодын сургалт, урьдчилан сэргийлэх ажлуудыг хийсэн. Үүнд:

✓ Тасгийн дарга бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч, дэд хурандаа С.Энхбат Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах мэдүүлэг гаргагч 8 алба хаагчид ХАСХОМ мэдүүлэг гаргах талаар гарын авлага, зөвлөмж, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.

✓ Нийт албан хаагчдад албаны сургалтын фэйсбүүк хаягаар дамжуулан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм” сэдвээр,


Admin · Feb 16 · 📍
#Хичээл: 05 📄
ШШГБ-ын албан хаагчийн Тангараг, Авлига, ашиг сонирхол, Төрийн алба, ШШГТухай хуулиар хүлээсэн нийтлэг үүрэг ба хориглолт сэдвийг... See More




✓ Мөн “Төрийн албаны хууль, ШШГБ-н ажилтаны тангараг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Авлига, ашиг сонирхлын зөрчлийн хуульд заасан алба хаагчийн нийтлэг эрх үүрэг, хориглолт, хязгаарлалттай холбоотой зүйл заалт” сэдвээр гарын авлага бэлтгэн газрын сургалтын цахим хаягт байршуулан танилцуулж, Авлига албан

тушаалын болон аливаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх “АМЛАЛТ БАТАЛГААГ” гаргуулан авсан.

✓ Авлигатай тэмцэх газраас цахимаар зохион байгуулсан эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан болон төрийн албан хаагчдын давтан сургалтанд 2 удаа “ZOOM” праграмаар, 1, 2 дугаар сард байгууллагын эрх бүхий ажилтан, нийт албан хаагчдыг давтан сургалтад хамруулсан.






Авлигын эсрэг үйл ажиллагаа, мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд болон албан хаагчдад хүргэх соён гэгээрүүлэх ажлын талаар:

✓ Газрын хэмжээнд шинээр томилогдсон албан хаагчдад “АТГ-Олон нийтийн мэдээллийн төв” Авлигатай тэмцэх газрын фэйсбүүк, пэйж хуудсанд нэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн цаг үеийн мэдээ мэдээллийг түргэн шуурхай авч ажиллаж байна.



✓ Авлигатай тэмцэх газар болон холбогдох дээд шатны байгууллагаас ирсэн мэдээ, мэдээлэл, постер, шторкыг “ аймаг дахь Дундговь ШШГГ” фэйсбүүк хуудсанд нийтэлж олон нийтэд сурталчилсан. Үүнд:

- ✓ 1. 2023.03.13-нд АТГ-с нийтэлсэн “Авлигын гэмт хэрэг 3 Сэдэв: Алдагдах шахсан монголын баялаг” шторк
- ✓ 2. 2023.05.02-нд “Авлигын эсрэг гэрэл асаая” зурагт пост
- ✓ 3. 2023.05.30-нд АТГ-с нийтэлсэн 30 секундын бичлэг, 5 зурагт постер /




✓ Мөн Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг ухуулан сурталчлах, авлигын нийгмийн хор аюулыг тайлбарлан таниулах зорилготой “Аавын захиас”, “Тангараг” “Өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр”, “Шударга ёс гэж юу вэ?” сэдэвт богино хэмжээний 4 кино, контент, Нэг дусал подкаст, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарын утасыг сурталчилсан 2 төрлийн шторкыг иргэд үйлчлүүлэх танхимын зурагтаар иргэдэд хүргэж, сурталчлах ажлыг зохион байгуулан хэвшсэн.






✓ Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан 5 төрлийн буюу “Монгол улсын Авлигатай тэмцэх бодлогын хэрэгжилт тойм танилцуулга”, “Үнэт зүйлсийн боловсрол”, “Шудрага байдал ба олон нийтийн итгэл”, “Хувийн хэвшлийнхэнд зориулсан зөвлөмж” “Бодлогын хураамж” ном зурагт хуудасыг мэдээллийн тавиурт байрлуулж гарын авлага, тараах материалыг иргэдэд хүргэж хэвшүүлсэн.



✓ Авлигатай тэмцэх газраас санаачилсан “Зөвд зөв Шудрага зөв” аяны хүрээнд тус газрын Авлигагүй нийгмийн төлөө мэдээллийн самбарыг шинэчлэн Зөвд зөв, шудрага зөв самбарыг байршуулан Авлигатай тэмцэх газраас гаргасан мэдээ, мэдээллийг байршуулан иргэд, албан хаагчдад хүргэн ажиллаж байна.

Байгууллагын гаднах мэдээллийн урсдаг дэлгэц болон Цахим хуудас, мэдээллийн самбар, “Дундговь Аймаг Дахь Шшг” фэйсбүүк хаягт иргэд олон нийтээс мэдээлэл авах нээлттэй 89086319 утас ажиллуулж, албан хаагчдын авлига, ашиг сонирхолын талаарх гомдол мэдээллийг иргэдээс авах авлигатай тэмцэх газрын 110 дугаарын утас, саналын хуудас, хайрцагаар авах, өгөх боломжийг бүрдүүлж ажиллаж байна.



Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласантай холбогдуулан авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан "...НЭГДЬЕ" соён гэгээрүүлэх аянд 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нэгдлээ.

